

Х.ИТГЭЛТ: 2024 ОНД 1826 КМ ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЖ, ШИНЭЭР 21 ЗҮТГҮҮР АВЧ, ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНЭЭ НЭМЭГДҮҮЛНЭ

- 📌 2024 онд төмөр замын салбарт хийгдэх бүтээн байгуулалтуудыг дурдвал?
- 📌 2024 онд төмөр замаар 45.5 сая.тонн ачаа тээвэрлэж, 1826 км төмөр зам төмөр замын барилгын ажлыг эхлүүлнэ.
- 📌 Тодруулбал, баруун босоо чиглэлийн Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1255 км төмөр зам, зүүн босоо чиглэлийн Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426.6 км, Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн 430 км барилгын ажлыг эхлүүлнэ.
- 📌 Хөдлөх бүрэлдэхүүнээ нэмэгдүүлж, парк шинэчлэл хийх үү?
- 📌 2024 онд төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг 21 зүтгүүрээр нэмэгдүүлнэ. Тавантолгой төмөр замд Америк улсад үйлдвэрлэгдсэн хамгийн сүүлийн үеийн хүчин чадалтай CD70 серийн 16 зүтгүүр энэ оны гуравдугаар улиралд Монгол Улсад ирнэ.
- 📌 Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт өнгөрсөн 2023 онд ОХУ-д ажиллахдаа хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн нэмэлт протоколд гарын үсэг зурж, шинээр 5 зүтгүүр авахаар болсон. 2024 оны гуравдугаар улиралд багтаан дээрх 5 зүтгүүрийг Монгол Улсдаа хүлээн авна.